



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар A/162

Мөрөн сүм

Иргэнийг асрамжийн үйлчилгээнд
хамруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн, 19.2.2, 19.4, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын саналыг үндэслэн Тосонцэнгэл сумын 1 дүгээр багийн иргэн Сангаан Гүнд (ЧВ38101515), Бүрэнтогтох сумын Сангийн далай багийн иргэн Гомбосүрэнгийн Баяр (РГ50122015) нар нь өөрийн гэсэн гэр оронгүй, ганц бие, үр хүүхэд, ах дүү нь харж хандах боломжгүй, байнгын асаргаанд байх шаардлагатай тул дээрх нэр бүхий иргэдийн 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн асрамжийн байнгын үйлчилгээнд хамруулахыг Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн дарга (Т.Октябрьбаяр)-д үүрэг болгосугай.

2. Иргэн С.Гүнд, Г.Баяр нарыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвд албан ёсоор хүргэх ажлыг зохион байгуулж, хамтран ажиллахыг Тосонцэнгэл сумын Засаг дарга (Ц.Мөнхөө), Бүрэнтогтох сумын Засаг дарга (А.Аззаяа) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН